



International Organization for Migration (IOM)

The UN Migration Agency

**DTM**

# ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ТАНДАХ – МОНГОЛ УЛС ДАХЬ ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДАЛ

## СУУРЬ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН: ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ

1-р шат, 2018 он



# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН СУУРЬ ҮНЭЛГЭЭ

## 2018 ОНЫ 1-3 САР

### ОРШИЛ

Монголчууд эртнээс нааш урт, богино хугацаагаар нүүж, шилжиж, хөдөлгөөнтэй амьдарч ирсэн уламжлалтай. Тиймдээ ч, богино хугацааны (< 3 сараас) шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг системтэй байдлаар цуглуулдаггүй. Гэвч, сүүлийн үед Улаанбаатар руу чиглэсэн шилжилт нэмэгдэж байгаа нь уур амьсгалын өөрчлөлт зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалж байгаа бөгөөд үүнд эрүүл мэнд, боловсролын сайн үйлчилгээ хүртэх, ажил эрхлэлтийн илүү сайн боломж нөхцөлтэй болох хүсэл, шалтгаан голлож байна.<sup>1</sup>

Монгол орон газар зүйн өвөрмөц байршилтай, хөдөөгийн хүн ам нь мал аж ахуйн салбараас ихээхэн хамааралтай байдаг зэргээс уур амьсгалын өөрчлөлт, өвөл цагийн хүндрэлд өртөмтгий байдаг. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан ган, зуд<sup>2</sup> ын давтамж нэмэгдснээс хөдөөгүүр хүмүүсийн амьжиргаа залгуулах боломж хомсдож орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн ихсэх хандлагатай байна.

Хэрэв энэ хандлага үргэлжилсээр байвал, давтамж нь өсөн нэмэгдэж буй гамшгийн нөлөөгөөр орон нутгаас Улаанбаатарыг зорих шилжин суурьшигчийн тоо эрчимтэйгээр өсөн нэмэгдэнэ. Нийслэлийн захиргаа шинээр ирж буй шилжин суурьшигчийг байршуулж суурьшуулахад ихээхэн бэрхшээлтэй тулгарсаар байна. Гамшгийн бэлэн байдлыг хангах, онцгой байдлын үед зорилтот хариу арга хэмжээ авах зорилгоор Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ) нь тухайн газар дээр байгаа хүний тоог мэдэх, хүн амын шилжилт хөдөлгөөний талаархи тодорхой мэдээлэл авах шаардлагатай байгаа юм.

Тус оронд гамшигт үзэгдэл нэмэгдэж байгааг үндэслэн Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), Монгол Улс дахь гамшгийн бэлэн байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор шилжилт хөдөлгөөнийг тандах цогц мэдээллийн системийг бий болгох ажлыг эхлүүлсэн. Энэхүү системийг нэвтрүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөний талаар Шилжин суурьшилтын нөхцөл байдлын үнэлгээ (ШСБНҮ) хийх аргаар мэдээллийг цуглуулж боловсруулан, гамшгийн бэлэн байдлыг хангах, онцгой байдал үүссэн үед хэрэглэх боломж бүхий мэдээллийн сан үүсгэж байна.

ШСБНҮ нь шилжин суурьшиж буй хүн амын богино хугацааны нүүдэл, шилжин суурьшилтын талаарх мэдээллийг цуглуулж, боловсруулж байгаагаараа онцлог юм.

### АРГАЧЛАЛ

ОБЕГ-аас хэрэгжүүлэх мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл, стратеги нь ШСБНҮ-ийн дэлхийн аргачлал дээр тулгуурласан бөгөөд Монголын нөхцөл байдал, шилжин суурьшилтийн хэв маягт тохирсон юм. Цуглуулсан мэдээллийн өөр өөр түвшин нь Монгол улсын хүн амын цогц дүр төрхийг харуулахад хувь нэмрээ оруулна.

Энэхүү суурь үнэлгээнд ОУШХБ нь хүн амыг шилжин суурьшилтийн төрхөөр нь хоёр бүлэгт ялгадаг: оршин суугчид (тухайн байршил/газарт амьдарч буй аливаа хүн), шилжин суугч хүн ам (1-3 сарын дотор сумаас гарсан/сум руу шилжин ирсэн хүмүүс).

ОБЕГ, ОУШХБ - ын тодорхойлолтоор шилжин суугч гэдэг нь хэн нэгэн өөрийн хүслээр эсвэл ямар нэгэн гадны хүчин зүйлээс шалтгаалан нэг газраас нөгөө газар руу түр хугацаагаар, улирлын хугацаагаар, эсвэл бүрмөсөн шилжин суурьшихыг хэлнэ. Энэ нь малчдын богино хугацааны нүүдлээс эхлэн иргэдийн урт хугацаагаар, бүрмөсөн шилжин суух зэрэг шилжих хөдөлгөөний бүх хэлбэрийг хамарна.

Байршлын үнэлгээг нийслэл Улаанбаатарыг оролцуулалгүйгээр засаг захиргааны хоёрдахь шатны түвшинд (сум) явуулсан. ОУШХБ-тай зөвлөлдсөний үндсэн дээр ОБЕГ-аас олж тодорхойлсон гол мэдээлэгчтэй ярилцлага хийж, тухайн орон нутгийн хүн амын багцаа тоо, нүүж ирсэн болон нүүж явсан иргэдийн тоо, хөдөлгөөнд оролцсон сар, хаанаас хаашаа ямар шалтгаанаар нүүсэн талаар мэдээлэл цуглуулсан.

Энэхүү үнэлгээг 330 гаруй сумдад (Улаанбаатар орооогүй) явуулсан. Энэхүү тайланд зөвхөн Говь-Алтай аймаг дахь хүн амын шилжих хөдөлгөөнд хийсэн дүн шинжилгээг танилцуулна.


<sup>1</sup> Монгол Улсын Их Сургууль (МУИС), Нэгдсэн Үндэсний Байгууллагын Их Сургууль – Мерит болон Олон Улсын Шилжих Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ) (2018 он). “Монгол Улс дахь дотоод шилжилт Хөдөлгөөний ойлгож зохицуулах нь.”

<sup>2</sup> Зуд гэдэг нь Монгол Улсад тохиолддог өвөрмөц, удаан хугацаагаар өргэлжилдэг улирлын чанартай байгалийн гамшиг юм. Энэ нь зундаа ган болсны дараа өвөл, хаврын улиралд цаг агаарын нөхцөл байдал эрс доройтож, ус, бэлчээрийн дутагдал гарч их хэмжээний малын хорогдолд хөргэхийг хэлнэ

## ТОВЧ ТОЙМ

Говь-Алтай аймаг нь Монгол Улсын 21 аймгийн нэг юм. Тус аймаг нь улсын баруун хязгаарт, Улаанбаатар хотоос ойролцоогоор 1,012 километрын зайд байрладаг. Аймгийн төв нь Есөнбулаг сум. Тус аймгийн газар нутагт Алтайн нуруу баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтсон байдаг. Тус аймаг баруун, зүүн талаас өндөр уулсаар, өмнө зүгт говийн нутгаар хүрээлэгдсэн. Аймгийн нийт талбай нь 141,448 км<sup>2</sup> ба хамгийн дээд өндөрлөг нь 3,802м. Засаг захиргааны хувьд тус аймаг 18 суманд хуваагддаг. Цаг агаар нь өвөлдөө хүйтэн, зуны улиралд хуурай, халуун байдаг.

2018 оны 1-3 сард Говь-Алтай аймгаас нийт 877 хүн нүүж явсан.



Нүүж явсан иргэдийн олонхи нь (79%) 1-р сард явсан.

## ГОЛ ДҮГНЭЛТ

Хүн амын шилжилт хөдөлгөөний хандлагыг харвал Говь-Алтай аймгаас шилжин нүүх нь үргэлжилсээр байгаа бөгөөд цаг агаарын хүнд нөхцөл байдлын улмаас сум хооронд нүүн шилжих хөдөлгөөн нэмэгдсэн гэдгийг харуулж байна.

Олонхи хүн (Говь-Алтай аймгаас нүүж явсан нийт хүний 80 орчим хувь нь) гурван сумаас нүүсэн байна: Баян-Уул, Цогт, Есөнбулаг.

Дүн шинжилгээний үр дүнг харахад тус аймагт хоёр төрлийн үндсэн шилжилт хөдөлгөөн явагдаж байна:

(1) Аймаг доторх шилжилт хөдөлгөөн ихэвчлэн 1-р сард явагдсан ба энэ нь өвлийн цаг уурын ширүүн нөхцөл байдалтай холбоотой. Энэ төрлийн шилжилт хөдөлгөөн Баян-Уул сумд давамгайлж байна.

Баян-Уул сумаас нүүсэн бүх иргэд 1-р сард Говь-Алтай аймгийн бусад сум руу нүүж явсан ба энэ нь ихэвчлэн өвөлжилт хүндэрсэн байдалтай холбоотой гэж үзэж байна.

(2) Илүү сайн эдийн засгийн нөхцөл, ажил эрхлэх боломж олох зорилгоор Улаанбаатар хот руу чиглэсэн хөдөлгөөн 3-р сард явагдсан. Энэ төрлийн шилжилт хөдөлгөөн ихэвчлэн аймгийн төв Есөнбулаг сумаас гарсан.



### ХЭДЭН ХҮН ХААНААС НҮҮСЭН?


2018 оны 1-3 сарын хооронд нийт 877 иргэд Говь-Алтай аймгаас нүүж явсан байна.

Нүүж явсан иргэдийн тоо сумаас хамааран ихээхэн хэлбэлзэж байна. Олонхи иргэд нь (Говь-Алтай аймгаас нүүж явсан нийт иргэдийн 80% орчим) гурван сумаас нүүж явсан: Баян-Уул, Цогт, Есөнбулаг.


Дэлгэр, Хөхморьт эсвэл Чандмань сумаас нэг ч хүн нүүгээгүй байна.

Доорх газрын зураг дээр Говь-Алтай аймгаас нүүж явсан иргэдийн тоог сумаар харуулж байна.

Зураг 1: Говь-Алтай аймгаас 2018 оны 3-1 сард нүүж явсан иргэдийн тоо, сумаар.



Газрын зураг 1: Говь-Алтай аймгаас 2018 оны 3-1 сард нүүж явсан иргэдийн тоо, сумаар.



### ИРГЭД ХААШАА ЯВСАН?


Олонхи иргэд (82%) байнга оршин суудаг сумаасаа Говь-Алтай аймгийн өөр сум руу нүүсэн байна. Баян-Уул сумаас нүүсэн бүх иргэд аймаг дотроо өөр сум руу нүүсэн. Цогт сумаас нүүсэн иргэд мөн Говь-Алтай аймгийн өөр сум руу нүүсэн. Харин аймгийн төв Есөнбулаг сумаас нүүсэн иргэд нийслэл Улаанбаатар руу нүүсэн байна.

Очих газар нь 2018 оны 1-3 сарын хооронд нилээд хэлбэлзэж байв. 1-р сард олонхи иргэд (93%) Говь-Алтай аймгийн өөр сум руу нүүсэн бол, 2-р сард энэ хувь хэмжээ нь 1-р сард байсан 93%-аас 47 хувиар буурч 46% боллоо.


3-р сар ба 2-р сард Улаанбаатар руу нүүсэн иргэдийн хувь хэмжээ өссөн. 1-р сард, Улаанбаатар руу нүүсэн иргэдийн эзлэх хувь нь нийт нүүсэн иргэдийн 7 хувь байсан бол 2-р сард тал хувь нь болж, 3-р сард 62 хувь болж өсжээ.

Энэ өсөлт ихэвчлэн 2-3 сард Улаанбаатар руу Есөнбулаг ба Эрдэнэ сумаас нүүсэн иргэдийн тоо өссөнтэй холбоотой.


Зураг 2018 :2 оны 3-1 сард Говь-Алтай аймгаас нийслэл хот/өөр аймаг/Говь-Алтай аймгийн өөр сум руу нүүж явсан иргэдийн хувь.



Зураг 3: Говь-Алтай аймгаас 2018 оны 3-1 сард Говь-Алтай аймгаас нийслэл хот/өөр аймаг/Говь-Алтай аймгийн өөр сум руу нүүж явсан иргэдийн хувь, сараар.



Газрын зураг 2: Говь-Алтай аймгаас 2018 оны 3-1 сард Говь-Алтай аймгаас нийслэл хот/өөр аймаг/Говь-Алтай аймгийн өөр сум руу нүүж явсан иргэдийн тоо.






**ИРГЭД ХЭЗЭЭ НҮҮЖ ЯВСАН БЭ?**


Олонхи нь 1-р сард нүүсэн. Харин ямар сумаас нүүсэн нь бага зэрэг хэлбэлзэлж байлаа. Баян-Уул сумаас нүүсэн бүх иргэд ба Цогт сумаас нүүсэн иргэдийн 93% нь 1-р сард нүүсэн бол Есөнбулаг сумаас нүүсэн иргэдийн тал нь 3-р сард нүүсэн байна.

Есөнбулаг сумаас нүүсэн иргэд ихэвчлэн эдийн засгийн шалтгаанаар Улаанбаатар руу нүүсэн, харин Баян-Уул сумаас нүүхэд түлхсэн гол шалтгаан нь өвөлжилт хүндэрсэн нөхцөл байлаа. Энэ хандлагыг тус сум дахь 1-р сард эрс хүйтэрдэг цаг агаарын хүнд нөхцлөөр тайлбарлаж болно.


Зураг 4: Говь-Алтай аймгаас 2018 оны 3-1 сард Говь-Алтай аймгаас нүүж явсан иргэдийн хувь, сараар.



Зураг 5: Баян-Уул, Есөнбулаг, Цогт сумаас нүүж явсан иргэдийн хувь, сараар.



Газрын зураг 3: 2018 оны зудын байдал



ОБЕГ, Орон зайн мэдээлэл, технологийн тасаг